



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.
3. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 186 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, мэдээллийн техник хэрэгсэлд засвар, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллага програм хангамж худалдан авах, гэрээгээр гүйцэтгүүлэх, хүлээн авах, турших, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн удирдлага зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл

- 2.1.1. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл нь эрүүл мэндийн салбар дахь мэдээллийн технологийн асуудлаар бодлогын шийдвэр гаргах үүргийг хүлээнэ.
- 2.1.2. Зохицуулах зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх ба техникийн ажлын хэсэгтэй байна.
- 2.1.3. Зохицуулах зөвлөлийн орлогч дарга дараах чиг үүрэгтэй ажиллана.
 - 2.1.3.1. Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөж, хуралдааны өдрийг товлон
 - 2.1.3.2. Зохицуулах зөвлөлийн даргын эзгүйд хурлыг даргалах
 - 2.1.3.3. Зохицуулах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг Зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн сайдад танилцуулах
 - 2.1.3.4. Зохицуулах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд хяналт тавих
- 2.1.4. Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүрэгтэй ажиллана.
 - 2.1.4.1. Зохицуулах зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах
 - 2.1.4.2. Хурлын зарыг хурал болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө түгээх
 - 2.1.4.3. Зохицуулах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, түүнийг баталгаажуулах, зөвлөлийн гишүүдэд хүргүүлэх
 - 2.1.4.4. Хурлын шийдвэрийг шаардлагатай үед холбогдох байгууллага, хувь хүнд хүргүүлэх
 - 2.1.4.5. Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоо бүхий бичиг баримтын санг бүрдүүлэх, хөтлөх

2.2. Мэдээллийн технологийн талаар эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг

2.2.1. Аймаг, нийслэлийн ЭМГ, дүүргийн ЭМН, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг нь мэдээллийн технологийн хэлтэстэй, эмнэлгийн цахим мэдээллийн тогтолцоо нэвтрүүлсэн төрөлжсөн мэргэжлийн төв, төв эмнэлэг нь мэдээллийн технологийн албатай байна. Мэдээллийн технологийн алба, хэлтэсгүй байгууллага нь 40 компьютер тутамд нэг мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй байхаар тооцон ажиллана.

2.2.2. Мэдээллийн технологийн алба, хэлтэс нь дараах мэргэжилтэнтэй байна. Үүнд

- Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Програм хангамж хариуцсан мэргэжилтэн
- Өгөгдлийн сангийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Телемедициний үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Мэдээллийн технологийн алба, хэлтэс нь ажлын ачааллаас хамааран шаардлагатай тохиолдолд нэмэлт ажлын байрыг бий болгон ажиллана.

2.2.3. Эрүүл мэндийн байгууллага нь мэдээллийн технологийн мэргэжилтнээ 5 жил тутамд төгсөлтийн дараах сургалтанд байгууллагын зардлаар хамруулж байна.


2.2.4. Байгууллагын чиг үүрэг, ажлын байрны онцлогийг харгалзан өндөр, дунд, бага үзүүлэлттэй компьютер /журмын 3.3.2.2 заалт/ хэрэглэх ажлын байрны тоог тогтоож байгууллагын дарга, захирлын тушаалаар батлан, ажлын байрны тодорхойлолтонд тусгасан байна.

2.2.5. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг танилцуулж, үйлчлүүлэгчдийг лавлагаа мэдээллээр хангах зорилго бүхий веб хуудастай байна.

2.2.6. Мэдээллийн технологийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тухайн жилийн төсөвт тусгаж шийдвэрлэнэ. Үүнд:

- Интернэтийн төлбөр
- Хорт кодын (virus) эсрэг програм худалдан авах зардал
- Шинэчлэх болон нэмэлтээр шаардлагатай мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн зардал /Мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу тооцно/
- Засвар, үйлчилгээний зардал
- Вэб хуудасны домайн нэрийн төлбөр
- Бусад

Гурав. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн дэд бүтцэд тавигдах нийтлэг шаардлага



Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн техник, програм хангамжийн дэд бүтэц дараах хэлбэртэй байна. Үүнд:

- 3.1. Техник хангамж (Hardware)
 - 3.1.1. Өгөгдлийн сүлжээ
 - 3.1.2. Тооцоолох төхөөрөмж
 - 3.1.3. Бусад төхөөрөмж
- 3.2. Хэрэглээний програм хангамж (Software)
 - 3.2.1. Үйлдлийн систем
 - 3.2.2. Хорт кодын (virus) эсрэг хамгаалалт
 - 3.2.3. Баримт бичиг боловсруулагч хэрэглээний програм хангамжууд
 - 3.2.4. Сүлжээний орчинд ажиллах хэрэглээний програм хангамж
 - 3.2.5. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжууд

3.3 Техник хангамж (Hardware)

3.3.1 Өгөгдлийн сүлжээ

Эрүүл мэндийн байгууллагууд өгөгдөл дамжуулах сүлжээ, өгөгдлийн дамжуулах сүлжээнд ажиллах журамтай байна.

3.3.1.1 Дотоод сүлжээ (Local Area Network – LAN)

Эрүүл мэндийн байгууллагууд дотоод сүлжээ үүсгэхдээ дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Дотоод сүлжээний тойм зураг боловсруулна.
- Сүлжээг зохион байгуулахдаа нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан “Active Directory - Domain Controller” технологи ашиглан байгуулсан байна
- Сүлжээний холболтын төрлийг (топологи) сонгохдоо захын хоёр хэрэглэгч 5-аас илүүгүй хуваарилагч (switch) дамжин холбогдохоор тооцно.
- Сүлжээний кабелийн зам цахилгаан хүчдэлийн замтай цуг явахгүй байх ба соронзон орон үүсгэж болзошгүй төхөөрөмжөөс холуур байхаар тооцож зохион байгуулах ба боломжгүй нөхцөлд STP кабель ашиглан сүлжээг байгуулна. Хуваарилагчийн портын 20 хувийг нөөцөнд үлдээнэ.
- 2 төхөөрөмжийн хоорондын зай 100 метрээс дотогш байвал “UTP cat5” болон “UTP cat6” төрлийн кабель хэрэглэнэ. 100 метрээс дээш тохиолдолд шилэн кабелийн холболтыг тус тус хэрэглэнэ.
- Байгууллагын дотоод сүлжээний IP хаяг олголтыг ЭМЯ-наас баталсан хаяглалтын дагуу тохируулна. Үндсэн бүтэц нь дараах хэлбэртэй байна.

Төхөөрөмжийн төрөл	Төхөөрөмжийн нэр	IP хаяг
Чиглүүлэгч төхөөрөмжийн гадна гарцын хаяглалт		ISP өгөгдсөн IP хаяг
Чиглүүлэгч төхөөрөмжийн дотоод гарцын хаяглалт		xxx.xxx.0.1
Domain Controller	PDC	xxx.xxx.0.2
Серверүүд	server1 – serverN	xxx.xxx.0.3 - xxx.xxx.0.10
Сүлжээнд холбогдсон төхөөрөмжүүд	netprintN, netscanN	xxx.xxx.0.20 - xxx.xxx.0.29
Хэрэглэгчийн компьютер	pc1 – pcN	xxx.xxx.0.40 - xxx.xxx.255.255

3.3.1.2 Утасгүй сүлжээ (Wireless network)

Эрүүл мэндийн байгууллагууд нь хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулсан утасгүй сүлжээг үүсгэн ашиглаж болно.

- Утасгүй сүлжээ нь нэвтрэх нууц үг, сертификаттай байна.
- Утасгүй сүлжээний төхөөрөмжийн саадыг нэвтрэх чадвараас хамааруулан өөр хоорондын зайг тохируулж байршуулна.
- Утасгүй сүлжээний төхөөрөмжийг сүлжээний ачаалал, хэрэглэгчийн алслагдсан байдлаас хамааран сонгоно. Үүнд:
 - 802.11g
 - 802.11n тус тус байна.

3.3.1.3 Интернет холболт

- Эрүүл мэндийн байгууллагууд интернет холболттой байна.
- Интернетийн зохистой хэрэглээний талаар мөрдөх журамтай байна.
- Байгууллага нь дотоод сүлжээний хэрэглэгч болон интернэтээр дамжуулан иргэдэд үзүүлдэг үйлчилгээний ачааллыг тооцон үзэж интернетийн урсгалын хурдаа тодорхойлно. Аймгийн ЭМГ, НЭ, Дүүргийн ЭМН, НЭ болон түүнээс дээш шатны байгууллагууд өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ ашиглан интернетийн үйлчилгээ авна. Зөвхөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ADSL холболт ашиглахыг зөвшөөрнө. ADSL холболтын хурд нь 1024 Kbps –с дээш байна. Бусад байгууллагын хувьд
 - Аймгийн эрүүл мэндийн байгууллага E1 болон түүнээс өндөр хурд бүхий холболтыг,
 - Улаанбаатар хотод байрлах 50 хүртэлх хэрэглэгчтэй байгууллагад Fiber optic 4 Mbps-с доошгүй хурдтай холболтыг,
 - Улаанбаатар хотод байрлах 50 ба түүнээс дээш хэрэглэгчтэй байгууллагад Fiber optic 8 Mbps-с доошгүй хурдтай холболтыг тус тус хэрэглэнэ.
- Байгууллага бүр Домайн нэртэй байна.
- Интернет гарцын хамгаалалт (firewall)-тай байна. Гарцын хамгаалалт нь програм хангамжийн болон техникийн шийдэлтэй байж болох ба VPN (IPsec and PPTP/L2TP based) холболт үүсгэх боломжтой байна.

3.3.2 Тооцоолох төхөөрөмж

3.3.2.1 Сервер компьютерийн үзүүлэлт (minimum) нь хэрэглэгчийн тооноос хамаарна.

Хэрэглэгч (тоо)	CPU	RAM	HDD	RAID	Network adapter	UPS	Back up	OS
10 хүртэл хэрэглэгч	Single Xeon® 2x2MB Cache, 3.0 GHz-тэй дүйцэхүйц	4096MB 1066MHz	1TB, SATA II, 7200 rpm	-	2 ширхэг 100/1000 Mbps network adapter /5 PCI slot/	>1500 VA	+	64bit
10-50 хэрэглэгч	2 Dual Core Intel® Xeon® 2x2MB Cache, 3.0 GHz, 1333MHz FSB дүйцэхүйц	4-16 GB 1066MHz	1-2 ширхэг, 1TB, SATA II, 10000 rpm	+	>2 ширхэг 100/1000 Mbps network adapter /5 PCI slot/	>3000 VA	+	64bit
51 ба түүнээс дээш хэрэглэгч	2 Quad Core Intel® Xeon® 2x2MB Cache, 3.0 GHz, 1333MHz FSB дүйцэхүйц	>16 GB 1333MHz	>4 ширхэг, 1TB, SATA II, 10000 rpm	+	>2 ширхэг 100/1000 Mbps network adapter /5 PCI slot/	>5000 VA	+	64bit

3.3.2.2 Ажлын байрны компьютерийн үзүүлэлт ажлын байрны тодорхойлолтоос хамаарна.

Ажлын байр	CPU	HDD	RAM	Video	ROM	Ethernet Adapter	Keyboard mouse	Display	OS
Өндөр үзүүлэлт шаардсан ажлын байр ¹	Intel i7 (дүйцэхүйц)	1TB SATA 7200 rps	4096 MB /DDR 1333MHz/	AGP 8x /1024 MB/	Internal CD-DVD ROM /combo/	100/1000 Mbps	PS2, USB	19" LCD	64 bit
Дунд үзүүлэлт шаардсан ажлын байр ²	Intel i5 /дүйцэхүйц/	500GB SATA 7200 rps	4096 MB /DDR 1066MHz/	AGP 4x /512 MB/ эсвэл онбоард VGA	Internal CD ROM	100/1000 Mbps	PS2, USB	19" LCD	64 bit
Бага үзүүлэлт шаардсан ажлын байр ³	Intel i3 /дүйцэхүйц/	300GB	2048 MB /DDR 1033MHz/	AGP эсвэл онбоард VGA	Internal CD ROM	100/1000 Mbps	PS2, USB	19" LCD	32 bit

3.3.2.3 Зөөврийн компьютер (Notebook)

- Сүлжээнд холбогдох техник болон мэдээллийн аюулгүй байдлын нөхцөлийг хангасан ямар ч зөөврийн компьютер ашиглаж болно.

3.3.3 Бусад төхөөрөмж

Эрүүл мэндийн байгууллага өөрийн үйл ажиллагааны дагуу

- Хэвлэгч төхөөрөмжүүд (printer)
 - Лазер хэвлэгч
 - Хэвлэх нягтшил 1200x1200 dpi-аас багагүй
 - Хэвлэгчийн хор нь дунджаар 2000 хуудас хэвлэдэг байх
 - USB portoор холбогддог байх
- Дүрс оруулагч (scanner)
- Проектор (LCD)
- Вэб камер
- Цаг бүртгэл, хяналтын систем
- Харилцаа холбоо (IP phone, VoIP, PBX, Switching) г.м. бусад шаардлагатай тоног төхөөрөмж ашиглаж болно.

3.4 Хэрэглээний програм хангамж /Software/

Компьютерийн хүчин чадалд нь тохирсон хэрэглээний програм хангамжийг суулгана.

3.4.1 Үйлдлийн систем:

- MS Windows

¹ Дүрс оношлогооны тоног төхөөрөмжтэй холбогдох, зургийн боловсруулалт хийх

² Дүрс оношлогооны зураг унших, бичиг хэрэг, мэдээллийн сан бүрдүүлэлт, статистик тооцоо, нягтлан бодох

³ Баримт бичиг оруулах, ердийн ажлын

- Linux, түүний хувилбарууд
- Unix зэрэг байж болно.

3.4.2. Хорт кодын (virus) эсрэг хамгаалалт: Ашиглагдаж байгаа бүх компьютерт хорт кодын эсрэг хамгаалах (Antivirus) програм хангамж суусан байна.

3.4.3. Баримт бичиг боловсруулагч хэрэглээний програм хангамжууд:

- MS Office
- Open Office

3.4.4. Сүлжээний орчинд ажиллах хэрэглээний програм хангамжууд:

- Баримт бичгийн цахим эргэлт (document collaboration system)
- Зурвас солилцооны програм хангамж (messaging)
- Цахим шуудан солилцооны програм хангамж (mail)
- Ажлын төлөвлөлт (calendar)
- Уулзалт төлөвлөлт (contact management)
- Програм хангамжуудын үйл ажиллагааны төлөвлөлт (task management)
- Интернэт хөтөч (Internet Browser: Internet Explorer, Firefox, Opera, Google Chrome)
- Хамтран мэдээлэл эзэмшилт (File sharing)

3.4.5. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжууд

- Статистик мэдээ боловсруулалтын програм
- Эмнэлгийн мэдээллийн програм

Дөрөв. Мэдээллийн техник хэрэгслийн засвар, үйлчилгээ

Мэдээллийн техник хэрэгслийн засвар, үйлчилгээ гэж тухайн техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

4.1. Мэдээллийн технологийн алба, хэлтэс нь компьютер болон түүний дагалдах хэрэгслийн засвар, үйлчилгээг хариуцан гүйцэтгэнэ.

4.1.1. Мэдээллийн технологийн мэргэжилтэн нь мэдээллийн техник хэрэгсэлд дараах үйлчилгээг үзүүлнэ.

- Мэдээллийн техник хэрэгсэлд ашиглалтын карт хөтөлнө.
- Мэдээллийн техник хэрэгсэл ажиллагаагүй болсон тохиолдолд баталгаат засварын хугацааг тодорхойлно.
- Баталгаат хугацаа дуусаагүй тохиолдолд нийлүүлэгч байгууллагын засварын мэргэжилтнээр засвар хийлгэнэ.
- Мэдээллийн техник хэрэгсэлд доголдол, гэмтэл гарсан үед оношилж, хэвийн үйл ажиллагааг хангана.
- Хэрэглэгчийн буруутай үйлдлээс учирсан хохирлыг байгууллагын удирдлагын шийдвэрийг үндэслэн буруутай этгээдээр төлүүлнэ.
- Хэрэглэгчийн эзэмшиж байгаа техник хэрэгсэлд үзүүлэх үйлчилгээний жагсаалт гаргаж мөрдүүлнэ.

- Мэдээллийн техник хэрэгслийн хөргөлтийн эд ангид шаардлагатай үйлчилгээг тухай бүр хийж, тэмдэглэл хөтлөнө.
- 4.1.2. Байгууллагын хэмжээнд хорт кодын (вирус) эсрэг нэг програм хангамжийг сонгож, хэрэглэгч бүрт суурилуулна. Хэрэглэгчдийн програм зөв ажиллаж байгааг улирал тутамд шалгаж байна. Албан ёсны эрх (лиценз)-гүй програм хангамж ашиглахыг хориглоно.
- 4.1.3. Өгөгдлийн сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, гарсан саатлыг шуурхай арилгана.
- 4.1.4. Програм хангамжийн гэмтлийн үед хэрэглэгчийн өгөгдөл, мэдээний санг нөөцөлж, аюулгүй байдлыг хангана.
- 4.1.5. Засвар үйлчилгээний бүртгэл мэдээллийн тогтолцоотой байна.

**Тав. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамж
нэвтрүүлж, хөгжүүлэх**

5.1. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага


Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжид иргэний эрүүл мэндийн болон хүн амын эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хүний нөөц, эм хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүртгэлийн, телемедициний, эмчилгээ, оношилгооны, сургалтын чиглэлээр боловсруулан ашиглаж буй програм хангамж хамаарна.

- 5.1.1. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг нэвтрүүлэх шаардлага, техник, эдийн засгийн үндэслэлийг захиалагч байгууллага тодорхойлох ба Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дэргэдэх техникийн хорооноос санал авна.
- 5.1.2. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамж нэвтрүүлэх тохиолдолд Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлд танилцуулан зөвшөөрөл авна.
- 5.1.3. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийн бодлогын даалгаварыг захиалагч байгууллага тодорхойлох ба Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дэргэдэх техникийн хорооноос санал авна.
- 5.1.4. Үг хэллэгийн тайлбар, нэр томъёолол, шаардагдах стандартууд, нууцлал, аюулгүй байдлыг тодорхойлсон байна.
- Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамж нь үйл ажиллагааны төрлөөс хамааран ЭМЯ-наас батлан гаргасан Өгөгдлийн толь бичиг, HL7, DICOM зэрэг олон улсын стандартыг хангасан байна.
 - Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын талаар Монгол Улсын ISO/IEC СТАНДАРТ 17799:2007-ыг баримтална.

- 5.1.5. Гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийг дагуу сонгон шалгаруулна.
- 5.2. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг турших, хүлээн авах**
- 5.2.1. Нэвтрүүлж байгаа эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг үйл ажиллагаатай хэрхэн нийцэж байгааг 1-3 сарын туршилтын хугацаанд захиалагч тодорхойлно.
- 5.2.2. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг туршихад дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд:
- Хэрэглэгчийн шаардлагын дагуу ажиллаж байгаа эсэх
 - Програмын бичиг баримтын бүрдэл бүрэн эсэх
 - Системийн шаардлага
 - Архитектур, дизайн
 - ERD
 - Техникийн бичиг баримт /шаардлагатай тохиолдолд/
 - Гарын авлага
 - Үйлдлийн системүүдтэй зохицож байгаа эсэх
 - Програм нь Монгол хэл дээр бичигдсэн эсэх
 - Гарын авлага, ашиглах заавар Монгол хэлээр зохиогдсон эсэх
 - Мэдээллийн сантай ажиллаж байгаа тохиолдолд хандалтын хурд, найдвартай ажиллагаа, нууцлал бүрэн хангагдсан эсэх
 - Мэдээллийн нууцлал, нөөцлөлтийг зөв хийж байгаа эсэх
- 5.2.3. Туршилтын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлөөс ашиглах зөвшөөрлийг олгоно.
- 5.2.4. Туршилтын хугацаа гэдэгт програм хангамжид гаргасан баталгаат засварын хугацаанд орохгүй. Програм хангамжийг бүрэн хүлээж авсны дараа баталгаат хугацааг тооцож эхэлнэ.
- 5.2.5. Туршилтын хугацаанд хэрэглэж байсан нууц үгсийг мэдээллийн технологийн мэргэжилтэн сольж, ямар үгээр хэрхэн сольсон тайланг бичиж, битүүмжлэн хадгална.
- 5.2.6. Програмын хэрэглэх зөвшөөрөл нь тухайн байгууллагын хувьд ямар нэгэн хязгаарлалтгүй байна. Өөр байгууллагад шилжүүлэн хэрэглэх тохиолдолд Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн шийдвэр, зохиогчтой байгуулсан гэрээг харгалзан үзнэ.
- 5.2.7. Олон улсад ашиглаж байгаа болон ашиглагдаж байсан програмыг нэвтрүүлж туршихдаа монгол хэлэнд хөрвүүлж, хэрэглэх гарын авлагыг монгол хэл дээр бэлтгэсэн байна. Хэрэглэгч 20-иос доошгүй цагийн сургалтанд хамрагдсан байна.

Зургаа. Байгууллагын веб хуудас

- 6.1 Байгууллага веб хуудас ажиллуулахад дараах шаардлагуудыг урьдчилан хангасан байна. Үүнд:
- Веб хуудсыг байршуулах үйлчилгээ үзүүлэгч компанийг сонгоно.
 - Веб хуудас руу хандах домэйн нэрийг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-тай зөвшилцөн тогтооно.

- 
- Веб хуудсыг хариуцан ажиллах мэргэжлийн хувьд бэлтгэгдсэн ажилтан томилсон байна.
 - Веб хуудсыг тогтмол ажиллуулах, баяжуулах, мэдээллийг шинэчлэх, аюулгүй байдал, нууцлал хамгааллыг хангах талаар байгууллагын түвшинд баримтлах журамтай байна.
 - Веб хуудас боловсруулахад Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, ЭМЯ-аас гаргасан чиглэлийг баримтална.
- 6.2 Байгууллагын веб хуудасны бүтэц, агуулгыг захиргааны зөвлөлөөр хэлэлцэн, даргын шийдвэрээр батална.
- 6.3 Байгууллага веб хуудас боловсруулах, байршуулах, туршихад ЭМЯ-наас мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж болно.
- 6.4 Байгууллагын веб хуудаст дараах төрлийн мэдээллүүдийг заавал багтаасан байна. Үүнд:
- Статик мэдээлэл
 - Байгууллагын нэр, лого, эрхэм зорилго
 - Байгууллагын зорилго, зорилтууд
 - Байгууллагын бүтэц, тасаг нэгжүүдийн чиг үүрэг, холбоо барих утас
 - Байгууллагын шуудангийн хаяг, факс, утасны дугаар, и-мэйл хаяг
 - Холбогдох байгууллагуудын холбоос
 - Үзүүлж буй тусламж үйлчилгээтэй холбоотой журмууд
 - Веб хуудас хэрэглэгчдэд хандсан зааварчилгаа
 - Динамик мэдээлэл
 - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээ, мэдээлэл
 - Сар, улирал, жилийн статистик мэдээ, мэдээлэл
 - Төсөв, санхүүгийн мэдээлэл /Засгийн газрын 2012 оны 17-р тогтоол/
 - Үйлчлүүлэгчдээс санал авах, зөвлөгөө өгөх булан
 - Үзүүлж буй тусламж үйлчилгээтэй холбоотой иргэдэд зориулсан мэдээ, мэдээлэл
- 6.5 Веб хуудас дахь мэдээлэл нь дараах шаардлага хангасан байна.
- Үүнд:
- Бодит, үнэн зөв байх
 - Хуулиар нийтэд мэдээлэхийг хориглоогүй байх
 - Мэргэжлийн үг хэллэг, гадаад нэр томьёо хэрэглэхээс аль болох зайлсхийсэн байх
 - Unicode форматаар бичигдсэн байх бөгөөд Монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй байх